



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/170/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: [Enhtsoodol@audit.gov.mn](mailto:Enhtsoodol@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

**Аудитор Ш.Ганчимэг**

Утас: **99377360**

Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	1-2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11-12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	18
7. Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.13 № 36  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны зардлыг улсын төсвөөс 1,206,930.4 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 100.0 мянга, тусламжийн эх үүсвэрээс 47,955.8 мянга нийт 1,254,986.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 99.6 хувьтай хэрэгжжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Ус цаг уур, орчны шинжилгээний газраас халаалт, цэвэр бохир усны өр барагдуулахаар 10,229.6 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цаг агаарт зориудаар нөлөөлөх зардалд хуваарилсан 2,000.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж, зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

D:/bichighereg/2023A4toot

006020037

### **Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, аймгийн Засаг дарга нараар хянуулан ажиллажээ. Ус цаг уур орчны шинжилгээний газрын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ баталж, гүйцэтгэлийг 98.3 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,089,935,390.36</b>	<b>1,070,995,537.44</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,089,935,390.36</b>	<b>1,070,995,537.44</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>900,262,442.89</b>	<b>891,474,843.27</b>
35110	Тусгай зориулалттай материал	900,262,442.89	891,474,843.27
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>188,087,947.47</b>	<b>177,945,694.17</b>
35410	Бичиг хэргийн материал	1,865,978.00	1,351,988.00
35420	Аж ахуйн материал	103,277,598.47	94,501,335.17
35430	Сэлбэг хэрэгсэл	81,248,471.00	81,248,471.00
35440	Түлш, шатах тослох материал	835,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	860,900.00	843,900.00
35600	Мал амьтад	1,585,000.00	1,575,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>647,419,811.32</b>	<b>681,753,646.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>647,419,811.32</b>	<b>681,753,646.37</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>423,809,811.32</b>	<b>459,040,313.01</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	380,691,638.49	380,691,638.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,229,755.52)	(68,196,254.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,028,000.00	100,228,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,120,666.76)	(48,384,666.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,251,940.00	133,293,571.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,781,276.03)	(42,240,054.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,632,368.02	20,523,368.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,662,436.88)	(16,875,288.77)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>223,610,000.00</b>	<b>222,713,333.36</b>
39301	Програм хангамж	2,690,000.00	2,690,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(896,666.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	220,920,000.00	220,920,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,737,355,201.68</b>	<b>1,752,749,183.81</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,737,355,201.68</b>	<b>1,752,749,183.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,737,355,201.68</b>	<b>1,752,749,183.81</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	562,110,096.16	562,110,096.16
51101	Өмч: - төрийн	562,110,096.16	562,110,096.16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>894,036,723.22</b>	<b>909,430,705.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	894,036,723.22	894,036,723.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,393,982.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	281,208,382.30	281,208,382.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,737,355,201.68</b>	<b>1,752,749,183.81</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>979,688,413.85</b>	<b>1,364,997,709.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>74,578,037.85</b>	<b>96,381,901.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>74,578,037.85</b>	<b>96,381,901.18</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,578,037.85	96,381,901.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	74,373,037.85	96,281,901.18
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>905,110,376.00</b>	<b>1,268,615,808.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>856,739,000.00</b>	<b>1,254,886,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	856,739,000.00	1,254,886,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,371,376.00</b>	<b>13,729,608.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,371,376.00	11,729,608.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,000,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,005,316,246.45</b>	<b>1,349,603,727.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,005,316,246.45</b>	<b>1,349,603,727.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,005,316,246.45</b>	<b>1,300,591,909.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>726,474,600.00</b>	<b>1,034,022,311.43</b>
210101	Үндсэн цалин	494,640,900.00	756,955,700.00
210102	Нэмэгдэл	210,908,700.00	249,173,411.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,925,000.00	27,893,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>97,334,558.03</b>	<b>128,641,297.67</b>
210201	Тэтгэврийн даатгал	68,967,758.03	87,895,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,800.00	10,319,801.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,620,600.00	8,248,534.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,352,600.00	2,065,386.51
210205	Эрүүл мэндийн даатгал	14,328,800.00	20,111,775.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,687,007.00</b>	<b>31,444,738.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,191,727.00	4,034,630.00
210302	Түлш, халаалт	11,495,280.00	26,239,928.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,170,180.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>57,989,821.77</b>	<b>33,491,740.30</b>
210401	Бичиг хэрэг	823,792.00	1,549,360.00
210402	Тээвэр, шатахуун	4,243,376.00	6,015,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,734,500.00	4,357,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	314,436.15	1,890,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	648,900.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	50,014,817.62	19,539,780.30

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>69,011,686.87</b>	<b>19,038,062.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,711,686.87	17,367,062.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	871,000.00
210604	Урсгал засвар	45,000,000.00	800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,151,000.00</b>	<b>1,370,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,151,000.00	1,370,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,356,232.00</b>	<b>8,264,963.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,184,226.00	6,879,390.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	211,800.00	113,970.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,560.00	140,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,245.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,000.00	334,800.00
210807	Газрын төлбөр	368,401.00	165,343.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,311,340.78</b>	<b>44,318,795.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,650.00	520,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,860,690.78	43,798,795.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>49,011,817.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>47,955,514.57</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	47,955,514.57
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,056,303.33</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,056,303.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(25,627,832.60)</b>	<b>15,393,982.13</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>45,131,283.14</b>	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	45,131,283.14	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(45,131,283.14)</b>	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(70,759,115.74)</b>	<b>15,393,982.13</b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>905,315,376.00</b>	<b>1,268,715,808.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>205,000.00</b>	<b>100,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	205,000.00	100,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	205,000.00	100,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,000.00	100,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>905,110,376.00</b>	<b>1,268,615,808.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	856,739,000.00	1,254,886,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	856,739,000.00	1,254,886,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,371,376.00</b>	<b>13,729,608.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,371,376.00	11,729,608.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,000,000.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>898,875,173.03</b>	<b>1,266,490,008.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>898,875,173.03</b>	<b>1,266,490,008.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>898,875,173.03</b>	<b>1,217,478,190.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	726,474,600.00	1,034,022,311.43
210101	Үндсэн цалин	494,640,900.00	756,955,700.00
210102	Нэмэгдэл	210,908,700.00	249,173,411.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,925,000.00	27,893,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	97,334,558.03	128,641,297.67
210201	Тэтгэврийн даатгал	68,967,758.03	87,895,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,800.00	10,319,801.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,620,600.00	8,248,534.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,352,600.00	2,065,386.51
210205	Эрүүл мэндийн даатгал	14,328,800.00	20,111,775.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,777,007.00	30,609,738.00
210301	Гэрэл, цахилгаан	3,191,727.00	4,034,630.00
210302	Түлш, халаалт	8,585,280.00	25,404,928.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,170,180.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,731,676.00	12,108,880.00
210401	Бичиг хэрэг	890,000.00	1,081,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,371,376.00	5,875,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,734,500.00	4,357,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	165,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,800.00	629,680.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	552,000.00	55,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	552,000.00	55,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	46,498,100.00	2,076,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,109,000.00	55,000.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	389,100.00	871,000.00
210604	Урсгал засвар	45,000,000.00	1,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,151,000.00</b>	<b>1,370,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,151,000.00	1,370,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,356,232.00</b>	<b>8,074,963.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,184,226.00	6,689,390.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	211,800.00	113,970.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,560.00	140,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,245.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,000.00	334,800.00
210807	Газрын төлбөр	368,401.00	165,343.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>520,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	520,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>49,011,817.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>47,955,514.57</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	47,955,514.57
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,056,303.33</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,056,303.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,440,202.97</b>	<b>2,225,800.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>2,225,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>2,225,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>2,225,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,225,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>(2,225,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>6,440,202.97</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,440,202.97</b>	<b>00.00</b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	562,110,096.16	281,936,691.08	945,853,388.68	1,789,900,175.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	49,519.84	49,519.84
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>562,110,096.16</b>	<b>281,936,691.08</b>	<b>945,902,908.52</b>	<b>1,789,949,695.76</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(52,594,494.08)	(52,594,494.08)
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>562,110,096.16</b>	<b>281,208,382.30</b>	<b>894,036,723.22</b>	<b>1,737,355,201.68</b>
D01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>562,110,096.16</b>	<b>281,208,382.30</b>	<b>894,036,723.22</b>	<b>1,737,355,201.68</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>562,110,096.16</b>	<b>281,208,382.30</b>	<b>894,036,723.22</b>	<b>1,737,355,201.68</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,393,982.13	15,393,982.13
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>562,110,096.16</b>	<b>281,208,382.30</b>	<b>909,430,705.35</b>	<b>1,752,749,183.81</b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,254,986,200.00	1,253,929,896.67
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,254,986,200.00	1,253,929,896.67
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,207,030,400.00	1,205,974,382.10
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,034,068,000.00	1,034,022,311.43
210101	Үндсэн цалин	756,955,700.00	756,955,700.00
210102	Нэмэгдэл	249,212,100.00	249,173,411.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,900,200.00	27,893,200.00
210104	Урамшуулал	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,258,600.00	128,641,297.67
210201	Тэтгэврийн даатгал	87,895,800.00	87,895,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,340,600.00	10,319,801.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,272,600.00	8,248,534.20
210204	Ажилгүйдлийн даатгал	2,068,200.00	2,065,386.51
210205	Эрүүл мэндийн даатгал	20,681,400.00	20,111,775.96
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,759,500.00	20,380,130.00
210301	Гэрэл, цахилгаан	4,414,000.00	4,034,630.00
210302	Түлш, халаалт	15,601,500.00	15,601,500.00
210303	Цэвэр, бохир ус	744,000.00	744,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,110,100.00	10,108,880.00
210401	Бичиг хэрэг	1,081,200.00	1,081,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,876,100.00	3,875,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,357,200.00	4,357,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,900.00	165,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	629,700.00	629,680.00
2105	<b>Нормативт зардал</b>	55,000.00	55,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,000.00	55,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,302,300.00	4,301,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,280,800.00	2,280,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	871,500.00	871,000.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	1,370,000.00	1,370,000.00
210702	Дотоод албан томилот	1,370,000.00	1,370,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,106,900.00	7,094,963.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,717,000.00	5,709,390.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,200.00	113,970.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,500.00	140,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	334,800.00	334,800.00

210807	Газрын төлбөр	165,400.00	165,343.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,955,800.00</b>	<b>47,955,514.57</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>47,955,800.00</b>	<b>47,955,514.57</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,955,800.00	47,955,514.57
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,254,986,200.00</b>	<b>1,253,929,896.67</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,206,930,400.00</b>	<b>1,253,829,896.67</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,206,930,400.00	1,253,829,896.67
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>100,000.00</b>	<b>100,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>82.00</b>	<b>82.00</b>
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	73.0	73.0
620003	Үйлчлэх ажилтан	08.0	08.0

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,729,608.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,729,608.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,729,608.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,229,608.00</b>
210302	Түлш, халаалт	9,803,428.00
210303	Цэвэр, бохир ус	426,180.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>980,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	980,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>520,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	520,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,729,608.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,729,608.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,729,608.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

“ЦЭСБ аудит” ХХК

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь 2022 онд Цаг уур, орчны технологийн, мэдээлэл үйлчигээний, захиргаа санхүү аж ахуйн гэсэн 3 хэлтэс, 82 орон тоотой ажиллажээ. Цаг уурын шинжилгээний өртөө 6, цаг уурын харуул 25, нисэхийн болон агаарын чанарын хяналтын харуул, байгаль орчны шинжилгээний лаборатори, урьдчилан мэдээлэх товчоо, хөдөө аж ахуйн цаг уурын станц, усны судлалын станц, холбоо зангилгаа, уур амьсгалын хэсэг, цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц зэрэг 41 салбар нэгжтэй байна.

Түүнчлэн агаар, усан мандал болон газрын гадаргад явагдах цаг агаарын үзэгдэл, орчны бохирдол, таримал болон бэлчээрийн ургамлын үзэгдэл зүй, хортон шавьжны ажиглалт зэрэг шинжилгээ судалгааны хөтөлбөрт заагдсан ажиглалт, хэмжилт, судалгааг тасралтгүй хийж мэдээлж байна. Тус байгууллага нь Уур амьсгалын нөөцийг бүрэн ашиглуулах нөхцлийг бүрдүүлэх зорилго, чиг үүрэгтэй ажилладаг ба тайлант онд дараахь зорилтыг дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

1. Ус цаг уур орчны чанартай мэдээллээр аймаг орон нутгийн албан байгууллага, ард иргэдэд үйлчлэх
2. Байгалийн гамшигт үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх замаар хувь хүн, нийгэмд учрах хохирлыг бууруулахад төр захиргааны байгууллагуудыг цаг агаарын мэдээгээр хангах.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөгүй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналт хариуцсан ажилтан жилийн төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,393.9 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	1,089,935.4	1,070,995.5	(18,939.9)
Үндсэн хөрөнгө	647,419.8	681,753.6	34,333.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,737,355.2</b>	<b>1,752,749.1</b>	<b>15,393.9</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,737,355.2	1,752,749.1	15,393.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,737,355.2</b>	<b>1,752,749.1</b>	<b>15,393.9</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансдууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,070,995,5 мянган төгрөг болж 18,939.9 мянган төгрөгөөр буурчээ. Тайлант онд 22,377.3 мянган төгрөгийн бараа материал худалдсан авсан, 515.0 мянган төгрөгийн мал нас дэвшүүлсэн буюу төл хүлээн авсан, Цаг уур орчны шинжилгээний газраас 19,720.1 мянган төгрөгийн тусгай зориулалттай багаж, тоног төхөөрөмж, Шунхлай ХХК-аас 140.0 мянган төгрөгийн шатахууныг тус тус үнэ төлбөргүй хүлээн авчээ. Тайлант хугацаанд 42,152.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 19,539.8 мянган төгрөгийн бараа материал акталж, 1,070,995.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үүнээс 891,474.8 мянган төгрөг буюу 83.2 хувийг тусгай зориулалттай материал эзэлж байна. Тусгай зориулалтын материалын дансанд өндөр үнэтэй, үндсэн хөрөнгийн шинжтэй иж бүрдэл бүхий багаж, тоног төхөөрөмжийг багцлан нэг ширхэг гэж бүртгэлд тусгаж байгаа нь хэдийгээр үйлчилгээний зоируулалттай ч бүртгэлээр тавих хяналт сулрах эрсдэл гарч болзошгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 2,225.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 891.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан. Мөн тусгай зориулалтын материал данснаас шилжүүлсэн 3,200.0 мянган төгрөгийн 1 ширхэг мотоциклийг авто тээврийн хэрэгсэлд, 71,815.8 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмжинд бүртгэж, тайлант хугацаанд 43,798.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 681,753.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,752,749.1 мянган төгрөг болж 15,393.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 385,309.3 мянган төгрөгөөр буюу 39.3 хувиар өсөхөд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 363,505.4 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 21,803,9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 344,287.5 мянган төгрөгөөр өсөхөд бараа, ажил үйлчилгээний зардал 295,275.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 49,011.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

УЦУОШТ нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,414,280.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 234,213.0 мянган төгрөгөөр бууруулж 1,180,067.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнээс шалтгаалжээ. Тайлант жилд анхны батлагдсан төсвийг 2 удаа тодотгож, 1,254,986.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,254,886.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,250,243.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоор 100.0 мянга, нэмэлт санхүүжилтээр 13,729.6 мянган төгрөгийн орлого орж, 1,056.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,214,292.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,050.9 мянга, бусад урсгал зардлыг 5.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### *Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Үндсэн арга хэмжээ 80101	1,201,613.5	1,200,562.6	1,050.9	99.6
	Арга хэмжээ 80220	5,416.9	5,411.8	5.1	100
	Арга хэмжээ 80802	47,955.8	47,955.5	0.3	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн харилцах дансанд Ус цаг уур, орчны шинжилгээний газраас халаалт, цэвэр бохир усны өр барагдуулахаар 10,229.6 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цаг агаарт зориудаар нөлөөлөх зардалд хувиарилсан 2,000.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна. Тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### ***3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Ус уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах тухай зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Бүжингоо нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,254,476.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,544.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Энэ хуулийн хүрээнд цалин, НДШ-ийн зардал 663.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчидын оронд шинэ ажилтан орсноор цалингийн шатлал буурсан, тогтмол зардлын хэрэглээтэй холбоотойгоор 379.4 мянга, бусад зардал 13.9 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д хамаарах 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр 76 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	0	3	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 75,540.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 75,540.8 мянган төгрөгийн алдааг залруулж, дотоод хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл хугацаа хоцроосон зөрчилд зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллагын дотоод хяналт шалгалтын журам нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ажуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-тай нийцээгүй байна. Дотоод хяналт шалгалтыг жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь дээрх журмын 3-д Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг, 3.7-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна”, 3.7.1-д “зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнаж” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтын журмыг шинэчилж, шалгалтыг удирдамж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж байх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд нэг мэдээллийг хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. дэх заалттай нийцэхгүй байна. Энэ нь хэрэглэгчдэд үнэн зөв мэдээллийг хугацаанд нь хүргэхгүй байх үр дагавартай.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





